



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2018 оны 03 сарын 07 өдөр

Дугаар 03

Өндөрхаан

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Хурлын 2018 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 15 цаг 10 минутад аймгийн Засаг даргын зөвлөлийн өрөөнд Төрийн албаны салбар зөвлөлийн гишүүн Ж.Гантулга, Л.Бат-Октябрь, Г.Болд, Ж.Болд, Б.Сүнгээ, Б.Баярсайхан, нарийн бичгийн дарга Ч.Болормаа нарын бүрэлдэхүүнтэй Төрийн албаны салбар зөвлөлийн дарга Ж.Ганбаатар удирдан эхлүүлэв.

Хэлэлцсэн асуудал:

1. Төрийн албаны зөвлөлийн Хэнтий аймаг дахь салбар зөвлөлийн 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэх
2. Боловсрол соёл урлагийн газрын Байгалийн ухааны мэргэжилтний сул орон тоо

СОНССОН НЬ 1:

ТАЗСЗ-ийн дарга Ж.Ганбаатар: Төлөвлөгөөг төслөөр тараагаад өгсөн байгаа болохоор гишүүд саналаа хэлнэ. Анхаарах зүйл ерөнхийд нь хараад өөр өөрсдийн оногдсон ажил дээр саналаа хэлээд явна. Төлөвлөгөөн дээр миний санал:

Өргөдөл гомдолтой асуудлыг Б.Баярсайхан гишүүн хариуцна.

4.2 Төрийн албан хаагчийн хувийн хэргийг Төрийн албаны зөвлөлөөс баталсан журмын дагуу бүрдүүлсэн эсэх, хувийн хэргийн бүрдүүлэлтэд хяналт тавих, заавар зөвлөмж өгөх дээр Г.Болд, Ж.Болд гишүүнийг Г.Лхагвахатантай оруулаад бид төрийн бүх байгууллагуудад ажиллах боломжгүй тул түүвэрчлээд удирдамж гарган хэсэгчлээд явбал 11 гишүүнээс Болормаа бид 2-ыг хасаад 9 гишүүн 3, 3-аараа хуваагаад 3 ажлын хэсэг болоод 1 хүн 3 байгууллагад ажиллаж, үзлэг явуулаад зөвлөгөө өгч ажиллана.

15, 16,17,18-ыг бүх гишүүдэд хариуцуулах. Ажлын хэсгийн удирдамжид оруулж өгөөд салбар зөвлөлөөс өгсөн үүрэг даалгаврын биелэлт ямар байна вэ гэдэг нь энэ ажлын үзүүлэлт болоод явна.

22 дээр Төрийн албан хаагчийн тангараг өргөх саналыг хүлээн авах, салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх, ёслолын үйл ажиллагааг зохион байгуулах нь Ч.Болормаа, Ж.Гантулга хариуцна. Хөндлөнгийн байгууллагаар салбар зөвлөлийг үнэлүүлэх Б.Сүнгээ. Ингээд 25 ажил байна.

Гишүүн Б.Баярсайхан: Энэ дээр нэг санал хэлэхэд 2016 онд байгууллагуудаар явсан. Миний бодлоор үр дүнг тооцох ажил хангалтгүй байна. 2016 онд миний мэдэхээр бол яг би явсан ажлын хэсгийнхээ зөвлөмж, албан тоотын төсөл боловсруулаад Болд даргад өгч байсан. Болд дарга тэрийг хэлэлцээгүй. 2017 онд ажлын хэсэг гараад бид бүх байгууллагаар яваад албан тоот боловсруулаад бэлдчихсэн. Яг тэрийг авч хуралдаанаар хэлэлцэх асуудал хийгдэхгүй байна. Тиймээс салбар зөвлөлөөс удирдамжийн дагуу хянаж шалгасан байгууллагад албан бичиг, зөвлөмж хүргэж байх, явсан үр дүнг харж байх хэрэгтэй.

ТАЗСЗ-ийн дарга Ж.Ганбаатар: Б.Баярсайхан гишүүний саналыг дэмжиж байна. 2018 оныхоо удирдамжийн төслийг гаргаад гүйцэтгэлийг нь тооцох тал дээр анхаарах. Үзлэгээ 1 сарын дотор явуулаад дүнгийн хурал нэгтгэсэн байдлаар хийгээд шаардлагатай бол өргөтгөсөн байдлаар хийж болно.

Шалгалтад хамрагдсан байгууллагын дарга, хүний нөөцийн ажилтан зэргийг оруулан хуралдаж болно.

Сумдруу хамгийн их өргөдөл гомдол ирж байгаа сумдруу явж болно.

Гишүүн Б.Баярсайхан: Сумд руу явах нь зүйтэй. Байгууллага сум хоёр хөтлөлт нь арай өөр өөр болохоор. Жишээ болгон ярихад.

Гишүүн Ж.Гантулга: 2 суманд ажиллаад онлайнаар бүх сумдтай холбогдоод ажилласан 2 сумын дүнгийн хурал хийгээд зөвлөгөө өгөн ажиллаж болно.

ТАЗСЗ-ийн дарга Ж.Ганбаатар: Ойрын нэг сум, холын нэг сумыг Бор-Өндрийг сонгоё. Ингээд аймгийн төвийн 9 байгууллага, 2 суманд 4 сард багтаан удирдамжийн дагуу ажиллана.

Төрийн албаны зөвлөлийн албан бичгийн дагуу тайлан мэдээ дээр заавал тусгаж байх 3 асуудал бол

-2017 оныг Хариуцлага үр дүнгийн жил болгон зарлаж байсан. Энэ жил ямар жил болгон зарласныг тодруулж байгаад хэлнэ.

-"Төрийн байгууллагуудад хууль тогтоомж, зөрчсөн үйлдлийг арилгуулах талаар зохион байгуулсан ажил" -ыг удирдамжид заавал оруулж өгөх

Өөр төлөвлөгөөн дээр санал байна уу? Байхгүй бол зарчмын хувьд батлах уу?

Гишүүд: байхгүй.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Гишүүдийн 100 хувийн саналаар Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэн батлан, тогтоол гарган төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллахыг салбар гишүүдэд үүрэг болголоо.

3//.

СОНССОН НЬ 2:

Боловсрол соёл, урлагийн газрын Байгалийн ухааны мэргэжилтний сул ажлын байрны захиалга

Нарийн бичгийн дарга Ч.Болормаа: БСУГ-ын Байгалийн ухааны мэргэжилтэн эрүүл мэндийн шалтгаанаар өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдөх хүсэлтийн дагуу тушаал гарган сул орон тооны захиалгаа ирүүлсэн байна.

ТАЗСЗ-ийн дарга Ж.Ганбаатар: Ажлын байрны тодорхойлолт огноогүй, үг үсгийн алдаатай тул буцаан өгч зөвлөмж хүргүүлэх,

Ажлын байрны тодорхойлолт шаардлага хангаж байна уу үгүй юу үзэх, гишүүн Б.Баярсайхан, Л.Бат-Октябрь хоёроор нягтлуулаад нийтлэг журамдаа нийцэхгүй, боловсруулах аргачлаа мэдэхгүй журмаа зөрчсөн үйлдэл байвал Боловсрол соёл урлагийн газар луу зөвлөмж хүргүүлээд тэрний дараа захиалгыг хүргүүлье.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Гишүүн Б.Баярсайхан, Л.Бат-Октябрь нар БСУГ-ын ажлын байрны тодорхойлолтыг нягтлаад Боловсрол соёл урлагийн газарт албан бичиг явуулна.

Хурал: 16:35 минутад дуусав.

ХУРАЛ УДИРДСАН:

Ж.ГАНБААТАР

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ
ХӨТӨЛСӨН:

Ч.БОЛОРМАА

